

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын хоёрдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/109/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Эл Би Экспэйншин Альфа аудит ХХК-ны Аудитор: Б.Бадамцэцэг Утас: 70432545 цахим хаяг:</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудитхийсэнцэвэрхөрөнгө/өмчийнөөрчлөлтийнтайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3.Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Албан шаардлага	12
4.2 Зөвлөмж	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Төсвийн захирагч

..... ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

..... -ын 20... оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Албан тушаал, Гарын үсэг, Тамга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31630073.00</u>	<u>35672901.75</u>
33	АВЛАГА	00.00	1,175,328.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,175,328.75
35	БАРАА МАТЕРИАЛ	31,630,073.00	34,497,573.00
354	Хангамжийн материал	31,630,073.00	34,497,573.00
35420	Аж ахуйн материал	20,421,573.00	22,831,573.00
35440	Түлш, шатах тослох материал	5,408,500.00	5,866,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,800,000.00	5,800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,342,456,679.56</u>	<u>1,335,078,665.52</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,342,456,679.56	1,335,078,665.52
392	Биет хөрөнгө	1,331,840,679.44	1,324,781,665.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,370,934,325.00	1,370,934,325.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-68,713,382.88	-91,617,843.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,725,990.00	42,575,990.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,299,582.64	-30,676,740.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,023,954.00	42,898,954.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,830,624.04	-9,333,019.56
393	Биет бус хөрөнгө	10,616,000.12	10,297,000.00
39301	Програм хангамж	1,375,000.00	1,375,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-758,999.88	-1,078,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,374,086,752.56</u>	<u>1,370,751,567.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.01</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.01
413	Өглөг	00.00	00.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,374,086,752.56</u>	<u>1,370,751,567.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,374,086,752.56	1,370,751,567.27
512	Хуримтлагдсан үр дүн	1,374,086,752.56	1,370,751,567.27
51210	Өмнөх үеийн үр дүн	1,374,086,752.56	1,374,086,752.56
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-3,335,185.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,374,086,752.56</u>	<u>1,370,751,567.27</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	358,340,600.00	418,722,475.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,499,000.00	26,725,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,499,000.00	26,725,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499,000.00	26,725,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499,000.00	26,725,000.00
122	Тусламжийн орлого	00.00	73,600.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	73,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,707,300.00	24,566,675.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	18,707,300.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,707,300.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	336,134,300.00	367,430,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	18,877,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	18,877,500.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	00.00	5,689,175.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	5,689,175.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	384,794,578.00	422,057,660.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,794,578.00	422,057,660.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381,077,119.48	378,556,827.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,601,089.48	271,664,506.05
210101	Үндсэн цалин	269,601,089.48	271,664,506.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,967,556.00	37,384,037.77
210201	Тэтгэврийн даатгал	24,032,318.00	26,517,330.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,733,810.00	2,716,677.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,187,047.00	2,173,341.78
210204	Ажилгүйдлийн даатгал	546,764.00	543,335.45
210205	Эрүүл мэндийн даатгал	5,467,617.00	5,433,352.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,698,069.00	17,356,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,829,259.00	3,319,300.00
210302	Түлш, халаалт	10,688,810.00	13,637,500.00
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,882,251.00	5,045,600.00
210401	Бичиг хэрэг	2,418,100.00	3,188,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,114,151.00	1,637,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	160,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	60,000.00
2105	Нормативт зардал	23,117,890.00	12,339,870.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,870,000.00	1,130,000.00
210502	Хоол, хүнс	20,878,290.00	10,945,870.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	369,600.00	264,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432,000.00	432,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл ТОГТООХ	432,000.00	432,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,378,264.00	34,334,014.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00	231,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,228,264.00	34,103,014.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,717,458.52	43,500,832.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	4,953,138.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	4,953,138.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,717,458.52	893,200.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,717,458.52	893,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	37,654,494.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	37,654,494.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,453,978.00	-3,335,185.30
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	73,600.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	73,600.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-26,453,978.00	-3,335,185.30

2.3 Аудитхийсэнцэвэрхөрөнгө/өмчийнөөрчлөлтийнтайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,374,086,752.56	1,374,086,752.56
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,374,086,752.56	1,374,086,752.56
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,374,086,752.56	1,374,086,752.56
D08	Тайлант үеийн үр дүн	-3,335,185.30	-3,335,185.30
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,370,751,567.27	1,370,751,567.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	354,841,600.00	391,997,475.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	24,566,675.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	18,877,500.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	00.00	5,689,175.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	354,841,600.00	391,997,475.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	354,841,600.00	391,997,475.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,124,141.48	348,496,642.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,475,484.48	271,993,265.73
210101	Үндсэн цалин	268,475,484.48	266,734,419.73
210102	Нэмэгдэл	00.00	5,258,846.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,624,947.00	38,230,606.83
210201	Тэтгэврийн даатгал	35,624,947.00	11,754,156.83
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	26,476,450.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,059,259.00	17,814,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,829,259.00	3,319,300.00
210302	Түлш, халаалт	13,050,000.00	14,095,000.00
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,662,611.00	4,195,600.00
210401	Бичиг хэрэг	936,150.00	2,338,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,406,461.00	1,637,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	320,000.00	160,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	60,000.00
2105	Нормативт зардал	23,397,890.00	14,749,870.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,170,000.00	1,410,000.00
210502	Хоол, хүнс	21,578,290.00	10,945,870.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	649,600.00	2,394,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	224,850.00	170,000.00
210604	Урсгал засвар	224,850.00	170,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432,000.00	432,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,247,100.00	911,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,247,100.00	911,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,717,458.52	43,500,832.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	4,953,138.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	4,953,138.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,717,458.52	893,200.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,717,458.52	893,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	37,654,494.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	37,654,494.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,308,400.00	347,760,605.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,308,400.00	347,760,605.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,308,400.00	347,760,605.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,433,400.00	273,310,372.56
210101	Үндсэн цалин	177,341,100.00	167,453,550.51
210102	Нэмэгдэл	76,745,900.00	83,894,542.82
210104	Урамшуулал	19,346,400.00	21,962,279.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,913,600.00	36,913,500.00
210201	Тэтгэврийн даатгал	25,976,200.00	25,976,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,734,300.00	2,734,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,187,500.00	2,187,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	546,900.00	546,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,468,700.00	5,468,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,707,500.00	17,814,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,212,500.00	3,319,300.00
210302	Түлш, халаалт	14,095,000.00	14,095,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,136,600.00	2,136,100.00
210401	Бичиг хэрэг	104,200.00	104,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,697,500.00	1,697,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,600.00	85,600.00
210404	Ном, хэвлэл	59,600.00	59,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	189,700.00	189,650.00
2105	Нормативт зардал	51,023,300.00	13,600,670.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,800.00	62,800.00
210502	Хоол, хүнс	50,366,200.00	10,945,870.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	594,300.00	2,592,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	170,000.00	170,000.00
210604	Урсгал засвар	170,000.00	170,000.00
2107	Томилолт, зочны зардал	107,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	107,600.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575,600.00	575,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	143,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3240800.00	3240063.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,240,800.00	3,240,063.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	386,308,300.00	347,760,605.56
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	367,430,800.00	334,159,935.56
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,430,800.00	334,159,935.56
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,877,500.00	13,600,670.00

132001	Орон нутгийн төсвөөс	18,877,500.00	13,600,670.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	27.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	08.00
620004	Гэрээт ажилтан	03.00	03.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	08.00	08.00
650010	Гэрээт ажилтан	03.00	03.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,689,175.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,689,175.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,689,175.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	736,037.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	736,037.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,953,138.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,953,138.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5689175.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,689,175.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,689,175.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын хоёрдугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Эл Би Альфа аудит ХХК -ны аудитор Б.Бадамцэцэг 2022 оны 02 дүгээр сарын 14-нээс 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган сумын 2 дугаар цэцэрлэг нь "хамт олны хандлага ёс зүйг сайжруулах, олон нийтийн оролцоонд суурилан хүүхэд нэг бүрийн эх хэлний чадвар, хөгжил, төлөвшлийн чанарт ахиц гаргах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, сургалтын орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, өөртөө үнэлгээ хийх, багш, хүүхдийг хөгжүүлэх, чиглүүлэх, эцэг эх, хүүхдийнхээ хөгжил төлөвшлийг дэмжих, багштай холбоо тогтоох, хамтран ажиллах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлжээ.

Үйл ажиллагааны чиглэл: Дээрх зорилго, зорилтын хүрээнд БСШУСЯам, аймгийн БСУГ-аас дэвшүүлсэн зорилго зорилтыг ханган сургуулийн өмнөх боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, орон нутгийн боловсролын төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж боловсролын үйлчилгээний хүртээмж, олон нийтийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэхэд үйл ажиллагаатайгаа уялдуулахад чиглүүлж ажилласан байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаж шинэчлэлт хийгдээгүй байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоо Боловсрол соёлын газар болон дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын хоёрдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 391997,5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын хоёрдугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3335.2 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны үлдэгдэл 34497.6 мянган төгрөг болж 2867.6 мянган төгрөгөөр буюу аж ахуйн материал, хичээлийн сургалттай холбоотой тавиур хэрэглэгдэхүүн зэргийн бэлтгэсэнтэй холбоотойгоор нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 32540,5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, 29672,9 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1342456,7 мянган төгрөг байсан бол оны эцэст 1335078,7 мянган төгрөг болж, 7378,0 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна .

Тайлант онд 26725,0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, акталж устгасан хөрөнгөгүй ба тайлант оны эцэст 1335078.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй ажиллагсадтай холбоотой авлага 1175,3 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1374086,8 мянган төгрөг байсан оны эцэст 1370751,6 мянган төгрөг тайлант онд 3335,1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 3335.1 мянган төгрөгийн алдагдалтай байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын 2-р цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 420877,6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 420877,6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас тус байгууллагын төсвийг 386308,7 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 386308,7 мянган төгрөгийн төсөв баталснаас 367430,8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 18877,5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 386308,7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 18877,5 мянган төгрөг нийт 367430,8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 347760,6 мянган төгрөгийг зарцуулж 38547,7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар Аймгийн ЗДТГ-аас 5689,2 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 146 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн зарлагын 1 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан боловч оны эцэст татан төвлөрүүлсэн 1 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1710.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, Жайка төслөөс олгосон 73.6 мянган төгрөгийн ариутгалын бодис, автомаскийг орлого аваагүй байсныг орлого авахуулж, залруулга хийж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.2.1 Анхан шатны баримт бүрдүүлэлт

4.2.1. Илрүүлэлт: Ник ХХК-аас шатахуун худалдан авахдаа И баримтгүйгээр зөвхөн нэхэмжлэл, зарлагын падаанаар орлого авч тайлагнасан 1637,1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг баримтлах, зардлыг нотлохгүй байх

Өгсөн зөвлөмж Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Татварын ерөнхий хуулийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахим илгээх үүрэгтэй" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.2.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналтын баг хийх ажлын төлөвлөгөөгүй хяналт хэрэгжүүлээгүйгээс нүүрс олгосон тооцооны хуудсанд тухайн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан боловч батлаагүй нэг хэвийн гарын үсгээр бичсэн, нүүрсний зарцуулалтад тавих хяналт сул, бүрэн бус анхан шатны баримтаар гүйлгээ гаргасан зөрчил илэрлээ.

Эрсдэл: Дотоод хяналтын алба дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, завших, дутах,

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт

тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

4.2.3 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан орон тооноос 2 хүн илүү ажиллуулж цалинжуулсан дутагдал илэрлээ.

Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах, төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг мөрдөөгүй тул холбогдох журмын заалтыг өөрчлөн ажиллах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын Булган 2-р цэцэрлэг	4	1710,7	1	73,6	0	0	0	0	3	1637.1

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АУДИТОР:

Б.БАДАМЦЭЦЭГ

